



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 4/56

Мандалговь

“Мандалговь хотын Багатойруу 4-р гудамжны 4 замын уулзварт авто замын гэрлэн дохио, босоо тэмдэг, хашлага суурилуулах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр хийгдэх “Мандалговь хотын Багатойруу 4-р гудамжны 4 замын уулзварт авто замын гэрлэн дохио, босоо тэмдэг, хашлага суурилуулах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Өлзийжаргал (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)

Ж.Элбэгзаяа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Н.Мөнгөн (Аймгийн Засаг даргын Тамгын газар

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Өлзийжаргал)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

438190123